



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 237

Улаанбаатар хот

Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны  
158 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 5.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн “Зохицуулалтын үйлчилгээний хөлсийг төвлөрүүлэх журам”-ын 158 дугаар тогтоолд дор дурдсан агуулгатай дараах 5 дугаар заалт нэмсүгэй:

1/ “5. Энэхүү тогтоолын тавдугаар хавсралтаар батлагдсан журмын 3 дугаар зүйлийн 3.5, 3.6, 3.7, 3.8 дахь хэсэгт заасан хөнгөлөлт нь 2015 оны зохицуулалтын үйлчилгээний хөлсөнд хамаарах бөгөөд тогтоол батлагдсан өдрөөс өмнө тооцсон зохицуулалтын үйлчилгээний хөлсийг дараагийн жилийн төлөх төлбөрт суутгаж тооцох ба эдгээр ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлээр холбогдох шийдвэр гаргаж ажиллахыг Хорооны дарга З.Нарантуяад зөвшөөрсүгэй.”

Хоёр. Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн 158 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Даатгалын байгууллагаас төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”-ний “Нэг. Тусгай зөвшөөрөл” хэсгийг дараах байдлаар өөрчлөн найруулсугай:

**1/ ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГААС ТӨВЛӨРҮҮЛЭХ ЗОХИЦУУЛАЛТЫН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭ**

№	Зохицуулалтын үйлчилгээ	Үйлчилгээний хөлс	Хугацаа
<i>Нэг. Тусгай зөвшөөрөл</i>			
1.1	Ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх	Өмнөх оны тайланд тусгагдсан даатгалын цэвэр хураамжийн орлогын 0.5% хувьтай тэнцүү <i>/доод хэмжээ 3,000,000.00 төгрөг, дээд хэмжээ 75,000,000.00 төгрөг</i>	Жил бүр

000021

		<i>байна/</i>	
1.2	Урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх	3,000,000.00 төгрөг.	Жил бүр
1.3	Давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх	3,000,000.00 төгрөг.	Жил бүр
1.4	Улаанбаатар хотод даатгалын зуучлагчийн мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх	300,000.00 төгрөг.	Жил бүр
1.5	Орон нутагт даатгалын зуучлагчийн мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх	150,000.00 төгрөг.	Жил бүр
1.6	Даатгалын хохирол үнэлэгчийн мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх	Даатгалын хохирлын үнэлгээний хураамжийн орлогын 0.45% хувьтай тэнцүү <i>/доод хэмжээ 300,000.00 төгрөг байна/</i>	Жил бүр
1.7	Улаанбаатар хотод даатгалын төлөөлөгчийн мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх	50,000.00 төгрөг.	Жил бүр
1.8	Орон нутагт даатгалын төлөөлөгчийн мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх	20,000.00 төгрөг.	Жил бүр

Гурав. Мөн тогтоолын тавдугаар хавсралтаар батлагдсан “Зохицуулалтын үйлчилгээний хөлсийг төвлөрүүлэх журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1, 3.6 дахь хэсгийг дараах байдлаар тус тус өөрчлөн найруулсугай:

**1/ 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг:**

“3.1. Даатгагч, давхар даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчоос жил бүр төвлөрүүлэх хөлсийг 2 тэнцүү хувааж, эхний төлбөрийг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор, дараагийн төлбөрийг тухайн жилийн 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор тус тус төвлөрүүлнэ.”

**2/ 3 дугаар зүйлийн 3.6 дахь хэсэг:**

“3.6. Хадгаламж зээлийн хоршоо нь Монголын хадгаламж зээлийн хоршоодын үндэсний холбооны гишүүн, 300.0 сая төгрөгөөс доош хэмжээний активтай бол жил бүр төвлөрүүлэх хөлснөөс бүрэн чөлөөлөгдөнө. Мөн холбооны гишүүн бусад хадгаламж, зээлийн хоршоо нь жил бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлснөөс 10 хувийн хөнгөлөлт эдэлнэ.”

Дөрөв. Мөн тогтоолын тавдугаар хавсралтаар батлагдсан “Зохицуулалтын үйлчилгээний хөлсийг төвлөрүүлэх журам”-ын 3 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай дараах 3.7, 3.8 дахь хэсэг нэмсүгэй:

**1/ 3 дугаар зүйлийн 3.7 дахь хэсэг:**

“3.7. Даатгалын зуучлагч нь Монголын даатгалын зуучлагчдын холбооны, даатгалын хохирол үнэлэгч нь Монголын хохирол үнэлэгчдийн холбооны гишүүн бол жил бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлснөөс 10 хувийн хөнгөлөлт эдэлнэ. Орон нутагт байгуулагдсан даатгалын хохирол үнэлэгчийн тухайн орон нутгаас олсон орлогыг хөлс тооцох дүнгээс хасч тооцно.”

**2/ 3 дугаар зүйлийн 3.8 дэх хэсэг:**

“3.8. Үнэт цаасны брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхэлж буй компани нь Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны гишүүн бол жил бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлснөөс 10 хувийн хөнгөлөлт эдэлнэ”.

Тав. Мөн тогтоолын “5” дугаар заалтыг “6” болгож, тогтоолын тавдугаар хавсралтаар батлагдсан “Зохицуулалтын үйлчилгээний хөлсийг төвлөрүүлэх журам”-ын 3 дугаар зүйлийн “3.7” дахь хэсгийг “3.9” болгон тус тус өөрчилсүгэй.

ДАРГА  З.НАРАНТУЯА